



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/357

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 35 дугаар дүгнэлтийн дагуу ӨВАХААГ/20240202005 урилгын дугаартай Арвайхээр сумын 1, 15, Бат-Өлзий сумын 3 дугаар цэцэрлэгүүдийг гал тогооны тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, тоглоомоор хангах тендерийн 1 дүгээр багц Арвайхээр сумын 1, 15 дугаар цэцэрлэг, Бат-Өлзий сумын 3 дугаар цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмжийг 30,966,000 (гучин сая есөн зуун жаран зургаан мянга) төгрөгөөр Чиглэл ХХК-иар, 2 дугаар багц Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн дотуур байранд зөөлөн эдлэлийг 18,535,000 (арван найман сая таван зуун гучин таван мянга) төгрөгөөр Жирмийн-Өгөөж ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээнд заасан хуваарь гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 31 0734

D:My Doc. Zahiramj. Zasag darga